

ХОРИГДЛЫГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE LEGAL REGULATION ON PREVENTING PRISONERS FROM COMMITTING CRIMES

Ч.Батболд

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, хууль зүйн доктор (Ph.D), дэд хурандаа

Товч агуулга: Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй дотоодын эрх зүйн зохицуулалт нь Олон Улсын гэрээ, конвенц болон дотоодын хууль, тогтоомжид нийцсэн байгаа хэдий ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан эрх зүйн актуудад шинжилгээ хийхэд хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хорих ангийн төрөл мэргэжлийн албадын мэдээлэл солилцох ажиллагаа, тохиолдлоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зүй дутагдалтай байна.

Түлхүүр үгс: Хорих ял эдлүүлэх ажиллагаа, гэмт хэрэг, зөрчил, арга зүй, урьдчилан сэргийлэх ажил.

Үндсэн хэсэг

Аливаа улс орны үндэсний эрх зүй нь тухайн улсын эдийн засаг, улс төр, соёл газар нутаг, үндэстэн ястан, эрх зүйн эх сурвалж зан заншил, шашин шүтлэгийн түүхэн болон тухайн цаг үеийн хүчин зүйлүүдээс нөхцөлдсөн уялдаа холбоо, харилцан хамаарлын нэгдэлд байдаг бөгөөд энэхүү шинжээс үүдэн эрх зүйн тогтолцоог хэд хэдэн бүлд хуваан авч үздэг.

Эрх зүйн бүл гэдэг нь эрх зүйн үүсэл, хувьсал, хөгжлөөрөө нэгдмэл, эрх зүйн эх сурвалж, эрх зүйн ухамсар, соёл боловсрол, бусад шинжээрээ ижил төсөөтэй улс орнуудын эрх зүйн тогтолцоог бүлэглэн авч үздэг ойлголт юм. Улс орнуудын эрх зүйн бүлийг хууль бүтээх зарчим, хуулийн хэрэглээ зэрэг үндсэн шинжээр Ром-германы, Англо-саксоны гэсэн хоёр үндсэн бүлд хуваах ба шашны болон овгийн уламжлалт, социалист эрх зүйн бүлд хамаардаг улс орнууд бас бий.

Ром-германы эрх зүйн бүлд эх газрын улс орнуудаас гадна, Латин Америкийн ихэнх улс, Африкийн зарим улс ч хамаардаг бөгөөд энэ эрх зүйн бүлийн онцлог нь Үндсэн хуулийн хэм хэмжээ тэргүүлэх байр суурь эзэлдэг ба хууль дээдлэх зарчим хэрэгждэг, материаллаг эрх зүйд тулгуурласан бүл юм. Харин Англо-саксоны эрх зүйн бүлд англи хэлтэй улс орнууд бүгд хамаарах ба энэ эрх зүйн бүл нь уламжлал ихтэй, эрх зүйн эрх сурвалж нь шүүхийн прецедент байна.

Монгол Улс нь эрх зүйн бүлийн хувьд Ром-германы эрх зүйн бүлд хамаарах хэдий ч хууль тогтоогчийн зүгээс зарим хууль тогтоомж, төрийн болон боловсролын байгууллагын тогтолцоо, бүтэц, эрх зүйн байдлын хэв маяг, агуулга нь Англо-саксоны хэв шинжийг агуулсан байх эсвэл холимог шинжтэй байх нь түгээмэл байна. Хэдийгээр Англо-саксон, Ром-германы эрх зүйн бүлийн хоорондын ялгагдах шинж нь тодорхой боловч аль давуу, илүү зөв үр дүн бүхий хувилбарыг сонгон холимог болон дангаар хэрэглэж болох талаар шууд үгүйсгэх нь өрөөсгөл болно.

Харин эрх зүйн хувьд хууль бүтээх, эрх зүйн аль бүлээс жишиг авч хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын тогтолцоо, бүтцийн үндсийг тодорхойлохдоо маш хянуур хандах шаардлагатай бөгөөд энэ нь хорих байгууллагын аюулгүй байдалд шууд бусаар нөлөөлөх нэг хүчин зүйл болох юм. Өөрөөр хэлбэл, хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын зорилго, зорилт, аюулгүй байдлыг хангах ажиллагааны тогтолцооны үр дүн нь эрх зүйн зөв зохицуулалт, гадаад улс орны дэвшилтэт жишгийг тусгасан, дотоодын онцлогийг бүрэн дүүрэн илэрхийлсэн хууль тогтоомжийн мөн чанараас тодорхой хэмжээгээр хамаарах зүй тогтолтой байна¹.

Хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар олон талаас нь судлахдаа хорих ял эдлүүлэх ажиллагааны хэлбэр, агуулга, хэрэгжүүлэх байгууллагын бүтэц, тогтолцоо, хөгжлийн бодлого, хүний нөөцийн бодлого зэргийг эрх зүйн хувьд хэлбэршүүлэн тогтоох талаар судлан авч үзэх нь зүйтэй.

Судлаачийн зүгээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд хорих ял эдлүүлэх ажиллагаанд тулгарч буй сорил, бэрхшээлийг хөндөн гаргахыг зорилоо.

1. Гэмт хэрэг хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль².

Хорих байгууллага нь төрийн зүгээс нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт явдалтай тэмцэх чиглэлээр явуулж буй эрүүгийн ялын бодлогыг хэрэгжүүлэгч нэг чухал субъект болохын хувьд Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн тусламжтайгаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хуулийн хүрээнд явуулах учиртай.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хорих байгууллагад үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тусгайлан заасан зохицуулалт байхгүй байгаа нь орон нутгийн гэмт хэргээс урьдчилан

¹ Очгэрэл, Ц. Хорих байгууллагын аюулгүй байдал. Уб., 2017. 132 дахь тал.

² Төрийн мэдээлэл. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга). Уб., 2019.

сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тус байгууллагад үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тусгадаггүй байна.

Өнөөдрийн байдлаар орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хамгаалалтын техник хэрэгслийг ажил хэргийн шугамаар биш гуйлга, хандив тусламж мэт өгч байгаа нь хуулийн зорилго, зорилт биелэгдэхгүй байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зорилго нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үндэслэл, журмыг тогтоож, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, алба хаагчийн эрх зүйн байдалтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Уг хуулийн 22 дугаар бүлэгт хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааг аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт, техникийн хяналт, хамгаалалт, биечилсэн хяналт, хамгаалалт, аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх, гүйцэтгэх ажил гэсэн төрөл, бүрэлдэхүүн хэсэгтэй байхаар хуульчилж өгсөн нь өмнөх хуулиудаас онцлог зохион байгуулалт болж өгчээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд байгууллага, алба нэгжийн чиг үүрэгт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвхөн үүргээр тусгаж өгсөн боловч түүнийг хэрэгжүүлэх арга, аргачлал арга зүй тусгагдаагүй.

3. Хорих ангийн дотоод журам².

Уг журмын зорилго нь хоригдлыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ял эдлүүлэх, ахуй нөхцөлөөр хангах, хорих ангид тогтоосон цагийн хуваарьт үйл ажиллагааг мөрдүүлэхэд оршино гэж заасан ба хоригдлын анх хорих ангид хүлээн авахаас суллагдах хүртэлх бүхий л үйл ажиллагааг зохицуулсан.

Цагийн хуваарийн дагуу явагдаж буй хөдөлмөр, сургалтын үед тэдгээрт хамрагдахаас татгалзсан хоригдлыг тогтоосон цэгт харуул хамгаалалтын хяналтад байршуулан хариуцсан нийгмийн ажилтан нь сургалт, хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар яриа, таниулга хийнэ

¹ Төрийн мэдээлэл. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (шинэчилсэн найруулга). УБ., 2017.

² ШШГЕГ. ШШГБ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. УБ., 2020. 160 дахь тал.

гэж тус тус хорих ангид явагдах үйл ажиллагааг нийтлэг байдлаар журамлаж өгсөн байна.

Хоригдлыг тогтоосон цэгт харуул хамгаалалтын хяналтад байршуулж байгаа нь гэмт хэрэг, зөрчлийг буруулж байгаа мэт боловч хоригдол бүтэн өдөр хяналтын цэгт сууснаар бухимдах, сэтгэл зүйн байдал тогтворгүй болж улмаар гэм хэрэг, зөрчил үйлдэх шалтгаан болж байна.

4. Хорих ангийн харуул хамгаалалтын журам¹.

Энэ журмаар хорих ангийн харуул хамгаалалтын зохион байгуулалт, хамгаалалтын бүс, хамгаалалтын ажилтны гүйцэтгэх чиг үүргийг тогтоож, хоригдолд байнгын хяналт тавих үйл ажиллагаатай харилцааг зохицуулна. Хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааг зохицуулсан заалтыг судалж үзвэл, журмын 2.1-д харуул хамгаалалт нь хорих ангид гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, цагийн хуваарьт үйл ажиллагааг чанд мөрдүүлэх, хорих анги, хоригдлын аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ, 2.2-д харуул хамгаалалтыг тасралтгүй зохион байгуулах бөгөөд байнгын, хүч нэмэгдүүлсэн, өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн гэсэн төрөлтэй ба хорих ангийн өдөр тутмын үйл ажиллагаа байнгын хамгаалалтад байна гэжээ.

Мөн журмын 7 дугаар зүйлд хорих ангийн дарга, харуул хамгаалалт гүйцэтгэх ажил эрхэлсэн дэд дарга нар харуул хамгаалалтыг удирдан зохион байгуулах, жижүүрийн бүрэлдэхүүний гүйцэтгэх үүргийг тодорхой зааж өгсөн. Тухайлбал, **ерөнхий жижүүр** жижүүрийн бүрэлдэхүүнийг хоригдлын зүгээс үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүргээр хангана, хоригдол оргох, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг шаардлагатай авч удирдлагад шуурхай мэдэгдэх, **гадна хамгаалалтын байцаагч** орголт, хамгаалалтын бүсийн тоног төхөөрөмжид халдахаас урьдчилан сэргийлэх, **ерөнхий жижүүрийн туслах** хорих ангийн гэрэлтүүлэг, хаалга, цоожны бүрэн бүтэн байдалд хяналт тавих, **хамгаалалтын ажилтан** хоригдлын бие, эд зүйлд үзлэг, нэгжлэг хийн, хориотой эд зүйлийг хураан авах, анхаарал татсан хоригдлыг байнгын хяналтад байлгаж, хөдөлгөөн бүрийг мэдэж байх, хариуцсан хэсгийг 20 минут тутам эргэж шалгах, **дүрс бичлэгийн хяналтын ажилтан** илэрсэн зөрчлийг холбогдох албан тушаалтанд шуурхай мэдээлэх, 30 минут тутам дүрс бичлэгийн хяналтын нөхцөл байдлыг ерөнхий жижүүрт илтгэх, дүрс бичлэг хийгдэж буй эсэхэд тогтмол хяналт тавих талаар үүргийг зааж өгсөн боловч тухайн үед ямар үүрэг гүйцэтгэх талаар тодорхой тусгаагүй, аргачлал байхгүй.

¹ ШШГЕГ. ШШГБ-ын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. УБ., 2020. 175 дахь тал.

5. Нийгмийн ажлын заавар¹:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/269 дүгээр тушаалаар нийгмийн ажлын зааврыг шинэчлэн баталсан.

Хоригдлыг нийгэмшүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, орчин нөхцөлд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн хувьд тогтвортой байлгах, хувь хүнийг төлөвшүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, нийгмийн ажилтны өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах зорилготой байна.

Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтэс болон хорих ангийн нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжийн чиг үүргийг тусгаж өгчээ. Энэ чиг үүрэгт хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, нийгэмшүүлэх ажлын арга, аргачлал байхгүй байгаа нь дутагдалтай байна. Тухайлбал, хоригдлын хувийн онцлог, аливаа зүйлд хандах хандлага, ар гэрийн харилцаа холбоо, орчны өөрчлөлтөөс шалтгаалан сэтгэл зүйд өөрчлөлт байгаа эсэхэд дүгнэлт хийж ангийн удирдлагад танилцуулна гэснээс өөрөөр хоригдолд чиглэсэн нэг бүрчилсэн нийгэмшүүлэх ажлын арга зүй байхгүй байна.

Мөн гэмт хэргийн хор уршгийг таниулах, нийгэмд учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт хөдөлмөрт хамрагдахын ач холбогдол, хуулиар олгогдсон эрх зүйн боломжийн талаар яриа таниулга хийнэ, уулзалт хийсэн, зөвлөгөө өгсөн талаарх нууцыг хадгалах ба амиа хорлох, гэмт хэрэг, зөрчил гаргах, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулах талаар яриа гаргасан тохиолдолд холбогдох албан тушаалтанд танилцуулна гэснээс өөр нөлөөллийн ямар арга хэмжээ авах гэмт санаа бодлоос татгалзуулах чиглэлийн хөтөлбөр байхгүй.

6. Сэтгэл зүйн ажлын заавар².

Уг заавар нь хоригдол, хоригдогсдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэн мэргэжлийн үйл ажиллагааны дараалал, арга, хэлбэр, хэрэгжүүлэх аргачлалыг тодорхойлж, сэтгэл зүйчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах зорилготой.

Хорих ангийн сэтгэл зүйч нь хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, тулгамдсан асуудалтай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ гэж заасан боловч сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хоригдлын сэтгэл зүйд эерэг нөлөөлөл

¹ www.cd.gov.mn

² ШШГЕГ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх хууль, тогтоомжийн эмхэтгэл. Уб., 2020. 352 дахь тал.

үзүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдсэн сэдэлд нь тохирсон арга хэмжээ авч, өөрийн бие эрхтэндээ гэмтэл учруулах болон гэмт хэрэг үйлдэж болзошгүй, сэтгэцийн хувьд тулгамдсан асуудалтай хоригдлын талаар ангийн удирдлага болон гүйцэтгэх ажилтанд заавал танилцуулна гэсэн нь сайшаалтай байна.

Хорих ангийн сэтгэл зүйч нь хоригдлын сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, тулгамдсан асуудалтай тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, сэтгэлийн хөдөлгөөний тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ гэж үүргийг заасан боловч гэмт хэрэг үйлдэж болзошгүй хоригдолд ямар сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх талаар аргачлал байхгүй.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үед хоригдлыг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх тусгай чиг үүргийн субъектүүдийн албан тушаалын тодорхойлолтод хэрхэн урьдчилан сэргийлэх болон хамтын ажиллагааны талаар тусгаж өгөөгүй байгаа нь учир дутагдалтай байна гэж үзлээ.

ДҮГНЭЛТ

1. Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулж буй хууль, дүрэм, журмууд нь хүний эрх, түүн дотроо хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаатуулан батлан гаргасан олон улсын эрх зүйн хэм хэмжээ (пакт, конвенц тунхаглал)-ний агуулга, хорих ял эдлүүлэх зарчимд нийцсэн, хоригдлыг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгэмшүүлэх үндсэн зорилготой уялдаж байгаа боловч хэрхэн нийгэмшүүлэх болоод гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар арга зүйг нарийвчлан тусгаж өгөөгүй байна.

2. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсрол, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ үүссэн гэж үзлээ.

3. Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх тусгайлсан эрх зүйн зохицуулалт үгүй хэдий ч хорих ял эдлүүлэх ажиллагаанд холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актад аюулгүй байдлыг хангах, харуул хамгаалалтын зохион байгуулалт болон хоригдлын үйлдсэн зөрчлийг шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалт хэрэгжиж байна.

САНАЛ

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хорин гуравдугаар бүлэгт “хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил” гэсэн бүлэг шинээр нэмж оруулах. Энэхүү бүлэгт:

- хоригдлын үйлсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох;
- хоригдлын үйлдэх гэмт хэргийн эрсдэлийг үнэлэх;

- хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт;
- хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй;
- хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албан тушаалтны чиг үүрэг зэрэг зохицуулалтыг багтаасан байх.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218 дугаар зүйлийн 218.2 дахь хэсэгт “хорих анги нь нийгэмшүүлэх ажлын мэргэшсэн нэгжтэй байх бөгөөд хоригдлыг хорих ангид хүлээн авмагц нийгэмшүүлэх мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэх төлөвлөгөө, **хувь хүнд тохирсон хөтөлбөр** боловсруулж ажиллана” гэж нэмж оруулах;

3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.5-д “гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн зан байдалд нөлөөлөх, хуулийг чандлан сахих дадал төлөвшүүлэх, хорих байгууллагад байх хугацаанд **дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх**, боловсрол, ажил хөдөлмөр эрхлэх дадал, туршлага олгох, суллагдсаны дараа нийгэмд дасан зохицох шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох” гэж нэмж оруулах;

4. Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын арга, аргачлалыг боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

5. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсролын зэрэг, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөрүүдийг шинээр боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.